

Үйлдвэржилт, хотжилтын үйл явц дахь Өвөр Монголын нутаг бэлчээрийн асуудлын талаарх Хятад дахь судалгааны өнөөгийн байдал¹

М. Бүрэнжаргал, Фан Фан, Ч.Бат-Эрдэнэ

Товч агуулга: *Үйлдвэржилт, хотжилтын явцад их хэмжээний бүтээн байгуулалтын чанартай газар нутаг зайлиггүй шаардагдана. Энэхүү явц дахь Өвөр Монголын тал нутгийн бэлчээрийн асуудал нь судлаачдын анхаарлыг ихээр татсан байдаг. Тус өгүүлэлд хятадын судлаачдын онол, арга зүй, үзэл баримтлалыг ерөнхийд нь дөрвөн хэсэгт хувааж шүүмжлэн өгүүлэв.*

Түлхүүр үг: *Өвөр Монголын нутаг бэлчээр, Хятад дахь судалгаа, үйлдвэржилт ба хотжилт*

XXI зуун гарсны дараа БНХАУ-ын “Тал нутгийн хууль”, “Хөдөө тосгоны газар шороог хариуцуулах хууль”-ийн суурин дээр БНХАУ-ын Хөдөө аж ахуйн яам, Өвөр Монголын Өөртөө Засах Орны намын хороо, Засгийн газар болон Сахилга бат хяналт шалгалтын хороо зэрэг байгууллагууд Өвөр Монголын нутаг бэлчээрийн асуудлын тухай холбогдох бичиг баримтыг боловсруулан мөрдүүлсэн билээ. Малын бэлчээрийг хууль бусаар эзэмшихийг устгах зорилгоор тал нутгийн “Хоёр эрх, нэг дүрэм”-ийг тууштай хэрэгжүүлж, хууль бусаар бэлчээр хагалбарлан ашиглахыг хориглосон юм. Гэвч Өвөр Монголын хөдөө нутгийн аймаг, хошууны хоёр шатны захиргаанаас эдийн засгийг

¹ Уг өгүүлэл 2013 онд батлагдсан БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны сангийн санхүүжилттэй залуучуудын төслийн (Дугаар:13CMZ058) хүрээнд бичигдсэн болно.

М.Бүрэнжаргал. Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын сургуулийн доктор, дэд профессор, санхүү эдийн засгийн чиглэлээр голлон судалгаа хийдэг.

Фан Фан. Өвөр Монголын их сургуулийн Эдийн засаг, менежментийн сургуулийн магистрант.

Ч.Бат-Эрдэнэ. Өвөр Монголын их сургуулийн Олон улсын сурган хүмүүжлийн сургуулийн докторант.

хөгжүүлэх зорилгоор хотжилт, үйлдвэржилтийн бодлогыг хүчтэй хэрэгжүүлсний улмаас тал нутгийн бэлчээрийг хууль бусаар эзэмших асуудал гарсаар байна.

Нөгөө талаар хятад судлаачид тариалангийн газрыг хятадын хотжилт, үйлдвэржилтийн явцад эзэмшсэн асуудлыг системтэй сайн судалсан ч малжих нутгийн бэлчээрийг мал маллахаас өөрөөр эзэмшсэн үзэгдэлд анхаарал хандуулалгүй иржээ. Тал нутгийн бэлчээрийг мал маллахаас өөрөөр ашиглахыг тариалангийн газрыг үр тариалахаас өөрөөр ашиглах асуудалтай зэрэгцүүлэн үзэж болохгүй юм. Хэдийгээр энэ хоёр асуудал нь мөн чанараараа газар нутгийг өөр хэлбэрээр ашиглаж байгаа үзэгдэл ч тэдгээрийн онцлог, өөрчлөгдсөн шалтгаан, нийгмийн үр дагавар нь маш тодорхой ялгаа заагтай болох юм. Тиймээс тариалангийн газрыг үйлдвэржилт, хотжилтын үйл явцад эзэмшүүлсэн тухай судлаачдын судалгааны үр дүнг Өвөр Монголын мал аж ахуй эрхэлдэг бүс нутагт шууд авч хэрэгжүүлэх нь бодит байдалд нийцэхгүй.

Өнөөг хүртэл БНХАУ-ын нутаг дэвсгэр дэх тал нутгийн асуудал, нутаг бэлчээр хорогдож байгаа болоод тэдгээрийн дотоод шалтгааны тухайд хийсэн судалгааг дөрвөн хэсэгт хувааж үзэж болно. Үүнд, Нэгдүгээрт - Тал нутаг ямар үнэ цэнэтэй вэ гэдэгт онолын үүднээс үнэлгээ өгсөн. Хоёрдугаарт - Өндөр технологи ашиглаж тал нутгийн бэлчээрийн үлдээд буй байдалд дүн шинжилгээ хийсэн. Гуравдугаарт - Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн талаас нь үйлдвэржилт, хотжилт болон газар шороог бүтээн байгуулалтын чанартай болгон өөрчилсөн асуудлын хоорондох харьцааг судалсан. Дөрөвдүгээрт - Тал нутаг багасч буй дотоод шалтгаан нь чухам юунд оршиж буйг судалсан зэрэг багтана.

Нэг. Тал нутгийн бэлчээрийн менежмент ба үнэлэмж

Судалгааны олон бүтээл хятадын тал нутгийн талаарх үнэлгээ, анализыг улам боловсронгуй болгож эдийн засаг, нийгэм, экологи орчны асуудалд жинтэй хувь нэмэр үзүүлжээ. Рэнь Жижоу 1982 онд нийтлүүлсэн “Тал нутгийн үндсэн байдал” өгүүлэлдээ хөдөө аж ахуйн онолын үүднээс АНУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас гаргасан тал нутгийн

*Үйлдвэржилт, хотжилтын үйл явц дахь Өвөр Монголын нутаг
бэлчээрийн асуудлын талаарх Хятад дахь судалгааны өнөөгийн байдал*

үндсэн байдлыг тодорхойлох аргыг ашиглан цаг агаар бол тал нутагт нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйл хэмээн дурдсан байдаг.² Нутаг бэлчээрийг ангилан тодорхойлох болон тал нутгийн үндсэн байдлын хоорондох ялгааг тайлбарласан нь түүний үндсэн шинж чанарын тухай үнэлгээ хийхэд онолын баримжаа өгчээ. Сун Лайюань, Чан Фэнрун нар 1994 онд нийтлүүлсэн “Тал нутгийн нөөц баялгийн үнэлгээ” өгүүлэлдээ эдийн засгийн ухааны үүднээс тал нутгийн бэлчээрийн үнэ цэнийн тухай онолын асуудал дэвшүүлэн гаргаж, тал нутгийн бэлчээрийн үнэ цэнийг тооцоолох арга зүй болон бодит загварыг дурдсан нь тал нутгийн бэлчээрийг үнэлэн ашиглах онолын баримжаа болжээ.³ Юй Жунлю, Ван Ямэй нар 1993 онд нийтлүүлсэн “Тал нутгийн нөөц баялгийн тооцоолол, түүнийг үндэсний нийт бүтээгдэхүүнд оруулж тооцоолох нь” өгүүлэлдээ тал нутгийн нөөц баялгийг тооцоолон шинжлэх арга зүйг дурджээ.⁴ Эрдэнэжав, Сарнай нар 2007 онд нийтлүүлсэн “Тал нутгийн үнэлгээний тухайд дахин өгүүлэх нь” өгүүлэлдээ тал нутгийн үнэлгээг хэрхэн тооцоолох асуудлын талаарх Засгийн газрын үнэлгээний механизм ба өрсөлдөөний механизмын ажиллагааг чангатгах тухай санал дэвшүүлжээ.⁵

Дээрх судлаачид эдийн засгийн ухааны үүднээс тал нутгийн бэлчээрийн эдийн засгийн үнэлгээг чухалчлан авч үзсэн бөгөөд тэдгээр судалгааны бүтээл нь тал нутгийн бэлчээрийн тухай үнэлгээ анализыг “үнэ цэнэ”-ээс “үнэ ханш” руу ороход чухал хувь нэмэр үзүүлжээ.

Харьцангуй дээр үеийн эдгээр судалгааны бүтээл нь тал нутгийн бэлчээрийн менежмент болон үнэлгээний системийг зөвхөн нэг өнцгөөс авч үзсэн ажээ. Харин сүүлийн үеийн судлаачид өмнөх үеийн судлаачдаас сургамж авч, үнэлгээний анализыг улам нарийн болгожээ. Судалгаанд эконометрийн арга зүй нэвтэрснээс хойш судлаачид

2 Рэнь Зижоу/任继周. Тал нутгийн үндсэн байдал/草原基况[J]. *Тал нутаг ба зүлэг/草原与草坪*, 1982, (6): 64-65.

3 Сун Лайюань/孙来源, Чан Фэнрун/常凤荣. Тал нутгийн нөөц баялгийн үнэлгээ/草原资源价值 (价格) 的初步探究[J]. Өвөр монголын мал аж ахуйн шинжлэх ухаан/内蒙古畜牧科学, 1994, (3): 21-24.

4 Юй Жунлю/于中流, Ван Ямэй/王亚梅. Тал нутгийн нөөц баялагын тооцоолол, түүнийг үндэсний нийт бүтээгдэхүүнд оруулж тооцоолох нь/草原资源核算及其纳入国民经济核算的研究[J]. *Хятадын хээр тал/中国草地*, 1993, (5): 13-17.

5 Эрдэнэжав/额尔敦扎布, Сарнай/莎日娜. Тал нутгийн үнэлгээний тухайд дахин өгүүлэх нь/再论草原价值[J]. Өвөр Монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг/内蒙古大学学报 (人文社会科学版), 2007, 39(1): 41-44.

онолын болон математик анализыг уялдуулах болсон нь энэ төрлийн судалгаа улам гүн гүнзгий, сайн болсон байна. Сун Румэй 2015 онд “Тал нутгийн нөөц баялгийн үнэлгээ шинжилгээ - Өвөр Монголын Шилийн хотоор жишээлэх нь”⁶; Лью Шинчао, Цуй Сю нар 2016 онд “Тал нутгийн нөөц баялгийн капитал, өр зээлийн арга зүйг буй болгох нь” хэмээх өгүүллийг тус тус нийтлэхдээ онолын ба математик анализыг уялдуулсан нь тал нутгийн бэлчээрийн үнэлэмжийн тухай судалгааг нэг алхмаар ахиулж чадсан байна.⁷

Хоёр. Тал нутгийн бэлчээрийн нөөцийн тухай судалгаа

Энэ зүйлийн судалгааны зонхилох хэсгийг агаарын камер RS, газар зүйн зураглал, GAS, GPS зэрэг аргад тулгуурлан газрын гадарга дээрх шинжилгээ ба газрын гадаргын эх материал авахтай уялдуулж, холбогдох судалгааны үр дүнг гаргасан байна. Эдгээр аргачлал нь хятадын тал нутгийн бэлчээрийн нөөцийг найдвартай харуулж чадах болжээ. Чяо Бинзюнь 1983 онд нийтлүүлсэн “Өвөр Монголын тал нутгийн нөөц баялгийг хиймэл дагуулаас тандан шинжилсэн нь” зохиолдоо RS-ээс авсан бичил зургийн хэмжилтийн үр дүн нь 95%-ийн үр дүнтэйг баталсан бөгөөд өнгөт бичил зураг болон MSSS, MSS7 хэлбэрийн дан долгионы зургийн барагцаалах талбай, ялгах төрөл зүйл нь сайн байсан гэдгийг нотолжээ.⁸ RS технологи, тэр дундаа сансрын RS технологийг зам харилцааны хөгжил сул, өргөн уудам тал нутагт судалгааны аргачлал болгон ашиглахад маш өндөр үр дүнтэй болохыг мэдсэн байна. Энэ нь хээрийн шинжилгээнд зарцуулах цагийг багасгаж, хүн хүч болон бусад зардлыг бууруулах, хээрийн шинжилгээний үр дүн сайн байх зэргийг баталгаажуулах давуу талтай болжээ.

Дээрх аргачлалыг хэрэглэснээс хойш ойрын жилүүдэд хятадын тал нутгийн бэлчээр их хэмжээгээр багасч байгааг, ялангуяа Өвөр

6 Сун Румэй/孙若梅. Тал нутгийн нөөц баялгийн үнэлгээ шинжилгээ - Өвөр Монголын Шилийн хотоор жишээлэх нь/草原资源资产管理评价研究—以内蒙古锡林浩特市为例[J]. Экологийн эдийн засаг/生态经济, 2015, 31(12): 88-92.

7 Лью Синьчао/刘欣超, Цуй Сю/翟琇. Тал нутгийн нөөц баялгийн капитал, өр зээлийн арга зүйг буй болгох нь/草原资源资产负债评估方法的建立研究[J]. Экологийн эдийн засаг/生态经济, 2016, 32(4): 28-36.

8 Чяо Бинзюнь/乔秉均. Өвөр Монголын тал нутгийн нөөц баялгийг хиймэл дагуулаас тандан шинжилсэн нь/卫星影响在内蒙古草原资源调查中的解释[J]. Хятадын хээр тал/中国草地, 1984, (04): 28-30.

*Үйлдвэржилт, хотжилтын үйл явц дахь Өвөр Монголын нутаг
бэлчээрийн асуудлын талаарх Хятад дахь судалгааны өнөөгийн байдал*

Монголын хээр тал ноцтой цөлжиж байгааг олж мэдсэн байна. Син Ци, Улаанбаатар нар 2005 онд нийтлүүлсэн “Өвөр Монголын тал нутгийн бэлчээрийн тогтвортой ашиглалт” өгүүлэлдээ дараах дүгнэлтийг хийжээ. 2005 оны эцэс гэхэд Өвөр Монголын тал нутгийн нийт талбай 74 918 500 га, тэр дундаа ашиглаж болохуйц тал нутгийн талбай 62 931 300 га болжээ. XX зууны 80-аад оныхтой харьцуулахад Өвөр Монголын тал нутгийн талбай 38 866 000 га-гаар багасчээ. XX зууны 60-иад оны тал нутгийн талбайтай харьцуулахад дөчин жилийн хугацаанд тал нутгийн талбай 10 034 300 га-гаар багасчээ. Энэ байдалд үндэслэн судлаачид тал нутгийн бэлчээрийн цөлжилтийн дотоод шалтгаан нь юу вэ гэдэгт анхаарлаа хандуулж эхэлжээ.⁹ Ван Шисинь, Ян Шэнли нар 2008 онд нийтлүүлсэн “Хөлөнбуйрын тал нутгийн талбайн өөрчлөлтийн анализ” өгүүлэлдээ Хөлөнбуйрын тал нутгийн цөлжилт, доройтол нь нуур цөөрөм, зам харгуй, хот тосгон, хошуу суманд ойр газруудад илүү их байна хэмээн үзжээ. Хөлөнбуйрын тал нутгийн талбай нь 9 950 800 га болж XX зууны 80-аад оноос 1 347 300 га-гаар багасчээ. Тал нутгийн талбай багассаны гол шалтгаан нь их хэмжээгээр атар хагалбарлан тариа тарьсан ба хот суурьшил бий болсон, уурхай нээгдсэн, зам засагдсан зэргээс үүдэлтэй хэмээн дүгнэжээ.¹⁰ Үүнтэй ижил дүгнэлтэд хүрсэн бүтээлүүдийг дурдвал Гүнжиймаа, Улаантуяа нарын 2011 онд нийтлүүлсэн “Дархан Муумянган холбоот хошууны тал нутгийн нөөц баялгийн өнөөгийн байдлын талаарх RS зурагчилсан анализ” өгүүлэл,¹¹ Чу Чэнгун, Бай Юнчуань нарын 2010 онд нийтлүүлсэн “Өвөр Монголын шинээр нэмэгдэж байгаа элсэн шуурганы эх үүсвэр” өгүүлэл,¹² Ван Чэнань, Ань Чуньмэй нарын 2008 онд нийтлүүлсэн “Өвөр Монголын тал нутгийн шинээр нэмэгдсэн элсэн шуурганы эх үүсвэрийн шинжилгээ” өгүүлэл зэрэг багтана.¹³

9 Син Ци/邢旗, Улаанбаатар/乌兰巴特尔. 内蒙古草原资源及可持续利用对策[J]. Өвөр Монголын хадлан/内蒙古草业, 2005, 17(2): 4-6.

10 Ван Шисинь/王世新, Ян Шэнли/杨胜利等. Хөлөнбуйрын тал нутгийн талбайн өөрчлөлтийн анализ/呼伦贝尔草原资源面积变化分析[J]. Өвөр Монголын хадлан/内蒙古草业, 2008, 20(1): 49-51.

11 Гүнжиймаа/贡吉玛, Улаантуяа/乌兰吐雅. Дархан Муумянган холбоот хошууны тал нутгийн нөөц баялгийн эх сурвалжийн өнөөгийн байдлын талаарх RS зурагчилсан анализ/达茂旗草原资源现状的遥感制图分析[J]. Өвөр Монголын хадлан/内蒙古草业, 2011, 23(3): 57-60.

12 Чу Чэнгун/管成功, Бай Юнчуань/白永泉等. Өвөр Монголын шинээр нэмэгдэж байгаа элсэн шуурганы эх үүсвэр/内蒙古新增沙尘源[J]. Умардын хүрээлэн буй орчин/北方环境, 2010, 22(3): 16-18.

13 Ван Чэнань/王承安, Ань Чуньмэй/安春梅等. Өвөр Монголын тал нутгийн шинээр нэмэгдсэн элсэн шуурганы эх үүсвэрийн шинжилгээ/内蒙古草原新增沙尘源现状调查[J]. Геологийн шинжлэх ухаан/测绘科学, 2008, 33(3): 132-133.

Эдгээр судалгааны бүтээлүүд нь Өвөр Монголын тал нутгийн цөлжиж байгаа асуудал нь уул уурхайн ашиглалт болон хүн ам олширсонтой шууд хамаатай гэсэн дүгнэлтэд хүрчээ. Аж үйлдвэржилт болон хотжилтын үйл явц нь шууд буюу дам байдлаар тал нутгийн нөөцийн талбайг багасгаж байна.

Гурав. Үйлдвэржилт, хотжилт хийгээд тал нутгийн бэлчээр хоорондох нөлөөлөл, харьцаа

Энэ төрлийн судалгаа үйлдвэржилт, хотжилтын үйл явцад адил бус орон нутагт үүссэн нутаг бэлчээрийн ашиглалтын чанарт гарсан өөрчлөлтийн тухайд анхаарал хандуулсан байна. Үнэндээ уг асуудал нь зөвхөн ӨМӨЗО-ы эдийн засгийн хөгжлийн явцад гарсан үзэгдэл биш, харин Хятадын бүх газарт цаашлаад дэлхийн улс орнуудын эдийн засгийн хөгжлийн явцад тулгарсан нийгмийн асуудал юм. Ли Куй 2010 онд нийтлүүлсэн “Зүүн Азийн үйлдвэржилт, хотжилт ба тариалангийн газрын ерөнхий хэмжээний өөрчлөлтийн харьцуулалт” өгүүлэлдээ Япон, Өмнөд Солонгос, Тайвань болон Хятадын үйлдвэржилт, хотжилт нь тариалангийн талбай багассаны үндсэн шалтгаан хэмээн дурджээ.¹⁴ Гэвч хятадын олонхи муж оронд тариалангийн газрыг үр тариалахаас өөрөөр ашиглаж байгаа талаар судлаачид нэлээд судалсан юм. Ян Зяньюнь 2013 онд нийтлүүлсэн “Хэнань мужийн үйлдвэржилт хотжилтын түвшин ба тариан талбайн ИКС загварт тулгуурласан шинжилгээ” өгүүлэлдээ тус мужийн тариалангийн талбайд гурвалсан экологийн Kuznets curve model байгуулж Eviews soft-оор үйлдвэржилт, хотжилт болон тариан талбай хоорондоо тодорхой харьцаатай болохыг баталсан байна. Үүн лүгээ судалгааны бүтээл олон гарсан ба их төлөв адилхан дүгнэлтэд хүрчээ.¹⁵ Энэ мэт харьцаа нь тал нутгийн бэлчээрийн талбай өөрчлөгдөж байгааг магадлахад энэ аргыг хэрэглэж болно гэсэн үг юм. Үйлдвэржилт, хотжилтын үйл ажиллагаа нь тодорхой хэмжээний газар нутаг шаардах урьтач нөхцөлтэй байдаг.

14 Ли Куй/李魁. Зүүн Азийн үйлдвэржилт хотжилт ба тариалынгийн газрын ерөнхий хэмжээний өөрчлөлтийн харьцуулалт/东亚工业化、城镇化与耕地总量变化的协同性比[J]. Хятадын хөдөө тосгоны эдийн засаг/中国农村经济, 2010, (10): 86-95.

15 Ян Зяньюнь/杨建云. Хэнань мужийн үйлдвэржилт хотжилтын түвшин ба тариан талбайн ИКС загварт тулгуурласан шинжилгээ/基于EKC模型的河南省工业化、城镇化水平与耕地面积关系研究[J], Ус шороог хамгаалах судлал/水土保持研究, 2013, (2) : 213-222.

*Үйлдвэржилт, хотжилтын үйл явц дахь Өвөр Монголын нутаг
бэлчээрийн асуудлын талаарх Хятад дахь судалгааны өнөөгийн байдал*

Тиймээс газар ашиглалтад өөрчлөлт гарах нь зайлшгүй юм. Тариалах нутагт тариан талбай нь бүтээн байгуулалтын ашиглалтын газар болон өөрчлөгддөг бол тал нутагт бэлчээр нь бүтээн байгуулалтын газар болж хувирдаг. Иймд үйлдвэржилт, хотжилтын үйл явцад Өвөр Монголын их хэмжээний бэлчээр бүтээн байгуулалтын газар болон хувирах магадлалтай билээ. Тэрхүү харьцааг дээрх аргачлалаар нарийн тооцоолж судлах боломжтой юм.

Үйлдвэржилт, хотжилт нь тал нутгийн эко орчны тогтвортой хөгжилд нөлөөлсөн талаарх судалгааг нэлээд судлаачид хийжээ. Гай Жи-и 2006 онд нийтлүүлсэн “Үйлдвэржилт, хотжилт ба тал нутгийн эко системийн тогтвортой хөгжил” өгүүлэлдээ үйлдвэржилтийн явц нь тал нутгийн эко системийн тогтвортой хөгжлийг үл сөрж байх нөхцлөөр урьтал болгох хэрэгтэй хэмээн тэмдэглэжээ.¹⁶ Хөдөөгийн хүн амыг багасгах, тал нутгийн бэлчээрийн дарамтыг хөнгөлөж, эко системийг нь хамгаалах, хөрөнгө оруулах, хөдөөгийн иргэдийн боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийг хуримтлуулах зэрэг талаар чухалчлан үзсэн бөгөөд хөдөөд аж үйлдвэр хөгжүүлэх, хот суурин байгуулах нь тал нутгийн эко системийн тогтвортой хөгжилд сөрөг нөлөө авчирна хэмээн үзсэн байна. Үүнээс харахад тал нутгийн эко орчин нь хөрсний бүтэц зэрэг талаасаа тариалах нутгийнхаас өөр байж, хөдөөд тариалах нутгийн туршлагыг шууд авч хэрэглэх нь зүй зохисгүй хэмээн дүгнэжээ.

Ян Зяньюнь 2012 онд нийтлүүлсэн “Бүс нутгийн үйлдвэржилт хотжилтын эрин дэх тариалангийн газрыг хамгаалах асуудал – Хэнань мужийн жишээн дээр” өгүүлэлдээ Америк, Японоор жишээлж тус үзэлтээ дурджээ.¹⁷ Америкийн нутаг дэвсгэр өргөн уудам тул ашиглагдаагүй газар маш их байжээ. Үйлдвэржилт, хотжилтын үйл явцад тэдгээр ашиглагдаагүй газрыг ашиглалтад оруулсан юм. Тиймээс хүн оршин суудаггүй газрыг ашигласан болохоор тариан газарт өөрчлөлт гараагүй ажээ. Харин Японы газар нутагт хүн

16 Гай Жи-и/盖志毅. Үйлдвэржилт хотжилт ба тал нутгийн эко системийн тогтвортой хөгжил/工业化、城镇化与草原生态系统可持续发展[J]. Өвөр Монголын санхүү эдийн засгийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний бичиг/内蒙古财经学院学报, 2006, (1): 53-56.

17 Ян Зяньюнь/杨建云. Бүс нутгийн үйлдвэржилт хотжилтын эрин дэх тариалангийн газрыг хамгаалах асуудал – Хэнань мужийн жишээн дээр/区域工业化、城镇化时期耕地保护问题研究——以河南省为例 [J]. Бүс нутгийн эдийн засаг/区域经济, 2012, (9): 45-47.

олон, тариан газар хязгаартай. Хоёрдугаар дайны дараа Япон нь хүнд үйлдвэрийг хүчтэй хөгжүүлж тариалангийн газрыг төдийлөн чухалчлаагүй юм. Үйлдвэржилтийн шалтгаанаас болж тариалангийн газрыг их хэмжээгээр бүтээн байгуулалтын газар болгосон байна. Үүнээс харахад үйлдвэржилт, хотжилтын үйл явцад нэг загвар гэж байдаггүй ажээ. Заавал тухайн орныхоо бодит нөхцөл байдлаас үүсч, тус тусын загвараа сонгох хэрэгтэй байдаг аж. Өвөр Монголын тухайд хэдийгээр нутаг дэвсгэрийн хувьд хятадын бусад муж орноос өргөн уудам ч гэлээ үйлдвэржилт, хотжилтыг хэрэгжүүлэх бодит нөхцөл болон газар нутаг тун хязгаартай байдаг. Учир нь тал нутгийн эко системийн өвөрмөц онцлогоос шалтгаалж ихэнх бүсийн газар нутгийг бүтээн байгуулалтын газар болгож өөрчлөх боломжгүй юм. Эс бөгөөс хүрээлэн буй орчны ноцтой бохирдлын асуудалтай тулгарах болно.

Дөрөв. Дотоод шалтгааны тухай шинжилгээ

Судлаачид тал нутгийн бэлчээр газар ихээр алдагдаж буй явдлын дотоод шалтгааны тухайд анализ хийх асуудалд анхаарлаа хандуулан эрхзүйн болон системийн өнцгөөс уг сэдвийг судалжээ. Зарим судлаач тал нутгийн цөлжилт, доройтлын шалтгааныг тухайн нутгийн малчдын зүй зохисгүй мал маллагааны тогтолцоотой холбон үзсэн байна. Жишээлбэл, Ян Зюньлан 2003 онд нийтлүүлсэн “Хорчин зүүн гарын Хойд хошууны бэлчээрийн доройтол, цөлжсөн шалтгаан ба түүний гарцын тухай” өгүүлэлдээ мал маллах систем зүй зохистой байх эсэх нь тал нутгийг тогтвортой ашиглах асуудалтай шууд холбоотой юм. Хөдөөд улирлаар бэлчээр сэлгэж нүүдэллэн мал малладаг байв. Гэтэл ойрын жилүүдэд малын тоо толгой ихээр нэмэгдэж, бэлчээрийн талбай багасахыг дагалдан, малчид нүүдэллэхээ больсон байна. Жилийн турш бэлчээрийг амраахгүй ашиглах нь ургамлын бүрхэцийг ноцтой эвдрэлд хүргэдэг аж. Өвс ургамал байгалийн жамаараа ургаж чадахаа байж ургаж үржих чадвараа алдан улмаар мөхөх хэмжээнд хүрдгээс тал нутгийн бэлчээр доройтох үр дагаврыг авчирдаг. Иймээс мал маллах системээс болсон бэлчээрийн доройтол, цөлжилт нь ноцтой хэмжээнд байдаг гэжээ.¹⁸ Рэнь Зижоу 2012 онд нийтлүүлсэн “Мал маллах, тал

¹⁸ Ян Зюньлан/杨俊兰. Хорчин зүүн гарын Хойд хошууны бэлчээрийн доройтол, цөлжсөн шалтгаан ба түүний гарцын тухай/科左后旗草原资源退化、沙化原因和对策[J]. Өвөр Монголын хадлан/内蒙古草业, 2003, 15(1): 11-12.

*Үйлдвэржилт, хотжилтын үйл явц дахь Өвөр Монголын нутаг
бэлчээрийн асуудлын талаарх Хятад дахь судалгааны өнөөгийн байдал*

нутгийн эко системийн үндсэн хэлбэр-мал маллах шилжилтийн тухайд өгүүлэх нь” өгүүлэлдээ мал маллах арга хэлбэрийн ухагдахууны тухай тодорхойлолт хийжээ.¹⁹ Мал маллах шилжилт гэдэг нь дэлхийн хөгжил аж үйлдвэрлэлийн иргэншилд дэвшин орсны дараа бэлчээрийн мал аж ахуйн менежментийн систем шинэ үеийн технологийг хүлээн авч, мал маллах системийг шинэ хэлбэрээр төгөлдөржүүлж, түүнийг орчин үеийн хөдөө аж ахуйд дутагдаж болшгүй чухал нэг бүрэлдэхүүн болгохыг хэлнэ. Нутаг хувааж сэлгэн маллах нь түүний бодит илрэл бөгөөд мал маллахын сайн нөлөөг маш сайнаар дээшлүүлж чадах юм.

Зарим судлаач Өвөр Монголын тал нутгийн доройтол, цөлжилтийн гол шалтгаан нь зүй зохисгүй бэлчээр ашиглалт хэмээн үзэж байна. Бэлчээрийг зүй зохисгүй ашигласнаас болж тал нутаг их хэмжээгээр бохирдож, байгалийн гамшгийг улам ноцтой болгожээ. Сян Шаомэй 2011 онд нийтлүүлсэн “Өвөр Монголын тал нутгийн ашиглалт ба хүрээлэн буй орчны хамгаалалт” өгүүлэлдээ Өвөр Монголын тал нутгийн хүрээлэн буй орчин муудсан шалтгааныг нутаг бэлчээрийг зүй зохисгүй ашигласнаас болсон хэмээн тодорхойлжээ.²⁰ Түүний үзсэнээр Өвөр Монголын ихэнх газар нутагт бэлчээр, эрчим хүч, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг хэт ашигласнаас болж олон төрлийн аж үйлдвэр, бага дунд аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрийн үйл явц нь хүрээлэн буй орчны бохирдолд ноцтой байдлыг үүсгэжээ.

Цуй Гуо-ин 2002 онд нийтлүүлсэн “Өрөмчийн тал нутгийн бэлчээрийн хомсдол ба бэлчээр доройтлын шалтгаан” өгүүлэлдээ бэлчээр доройтлын шалтгааныг хоёр төрөлд хуваажээ. Нэг нь даац хэтэрснээс үүдэлтэй бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбогдох асуудал юм. Нөгөөх нь бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн бус шалтгаан бөгөөд уул уурхайн ашиглалт, олон төрлийн бүтээн байгуулалтын улмаас бэлчээр өөрчлөгдөх зэрэг болно гэжээ. 21

19 Рэнь Жижоу/任继周. Мал маллах тал нутгийн эко системийн үндсэн хэлбэр-мал маллах шилжилтийн тухайд өгүүлэх нь/放牧, 草原生态系统存在的基本方式——兼论放牧的转型[J]. Байгалийн баялаг/自然资源, 2012, (08).

20 Сян Шаомэй/相晓梅. Өвөр Монголын тал нутгийн ашиглалт ба хүрээлэн буй орчны хамгаалалт/浅谈内蒙古草原资源开发与环境保护[J]. Хөдөө аж ахуйн баялаг ба хүрээлэн буй орчин/农业资源与环境, 2011, (6).

21 Цуй Гуоин/崔国盛. Өрөмчийн тал нутгийн бэлчээрийн хомсдол ба бэлчээр доройтлын шалтгаан /乌鲁木齐地区草原占用情况及草场退化原因分析 [J]. Өвсөн тэжээлт гэрийн тэжээвэр/2002, 2, 152, 57.

Зарим судлаач хөрөнгийн эрхийн онолын үүднээс их хэмжээний тал нутаг бүтээн байгуулалтын ашиглалтанд шилжсэн тухай судалгаа хийжээ. Ян Ли 2007 онд нийтлүүлсэн “Тал нутгийн удирдлага: өрхийн хариуцлагын журмыг төгөлдөржүүлэх нь” өгүүлэлдээ нийтийн бэлчээрийн асуудлыг ноцтой байдалд хүргэсэн ба бэлчээр доройтлын шалтгаан нь нутгийн өрхийн хариуцлагын журмыг хэрэгжүүлснээс болсон юм биш, харин уг журмыг тууштай хэрэгжүүлээгүйгээс болжээ. Иймээс нутгийн өрхийн хариуцлагын журмыг улам сайжруулж, хөрөнгийн эрхийн онолоос тал нутгийн удирдлагад малчид, орон нутгийн захиргаатай хамтран оролцож байх саналыг дэвшүүлжээ.²² Зарим судлаач тал нутгийн өмчлөх эрхийн системийг сайжруулах талаас нь судалжээ. Жишээлбэл, Сун Лихун 2015 онд нийтлүүлсэн “Хятадын тал нутгийг ашиглах эрхийн тогтолцоо”, “Хятадын тал нутгийг ашиглах эрхийг шилжүүлэх тогтолцооны тухай шинжлэх нь” гэх хоёр өгүүлэлдээ нутгийн өрхийн хариуцлагын эрхийн системийг сайжруулах ба системийн шинэчлэлт хийх, нутаг бэлчээрийг өөрчлөх, ханшийн тогтолцоог буй болгох зэрэг талаар санал дэвшүүлж тал нутгийн эко системийг хамгаалах хийгээд эдийн засгийг хөгжүүлэх талаар гүнзгий судалгаа хийжээ.²³

Зарим судлаач их хэмжээний нутаг бэлчээр алдагдаж байгаагийн шалтгаан нь хуулийн цоорхой болон хуулийн хэрэгжилтийн тууштай бус байдлаас үүдэлтэй хэмээн үзжээ. Сюе Юань 2008 онд нийтлүүлсэн “Өвөр Монголын тал нутгийн нөөц баялгийн эрх зүйн хамгаалалт” өгүүлэлдээ бэлчээрийг хагалбарлаж ашиглах хэлбэрийг өөрчлөх нь нутаг бэлчээр багассаны үндсэн шалтгаан биш, харин үнэнхүү шалтгаан нь тал нутгийг хуулиар батлан хамгаалж чадахгүй байгаагаас үүдэлтэй гэжээ. Хятан улсын болон Өөртөө засах орны засгийн газраас тал нутгийн эх баялгийг хамгаалах тухай олон төрлийн хууль дүрмийг гаргасан ч тал нутгийг хагалбарлаж сүйтгэх байдал огтхон ч тасраагүй гээд тэрбээр холбогдох статистик тоо баримтыг харуулжээ. 1990 оноос хойш хууль бусаар тал нутгийг хагалбарласан хэрэг 1776

22 Ян Ли/杨理. Тал нутгийн удирдлага: өрхийн хариуцлагын журмыг төгөлдөржүүлэх нь/草原治理: 如何进一步晚上草原家庭承包制[J]. Хятадын хөдөө тосгоны эдийн засаг/中国农村经济, 2007, (12): 62-67.

23 Сун Лихун/宋丽弘. Хятадын тал нутгийг ашиглах эрхийн тогтолцоо/我国草原资源使用权制度[J]. Хятадын өвсөг хээр талын эрдэм шинжилгээний бичиг/中国草地学报, 2015, 37(3): 1-5. Сун Лихун/宋丽弘. Хятадын тал нутгийг ашиглах эрхийг шилжүүлэх тогтолцооны тухай шинжлэх нь/我国草原资源使用权流转制度探析[J]. Хятадын бэлчээр эрдэм шинжилгээний бичиг/中国草地学报, 2015, 37(4): 1-6.

Үйлдвэржилт, хотжилтын үйл явц дахь Өвөр Монголын нутаг бэлчээрийн асуудлын талаарх Хятад дахь судалгааны өнөөгийн байдал

гарсан ба түүнд 38400 га талбай өртжээ. 2014 онд ӨМӨЗО-ы засгийн газраас гаргасан бүртгэлд тал нутгийг эвдсэн хэрэг 1450 удаа, эдгээр хэрэгт холбогдсон хүний тоо 4980 болжээ. Иймэрхүү судалгаа, бүртгэлд хятадын нутаг бэлчээрийн хамгаалалт байнга чангарч, хууль тогтоомжоо тасралтгүй сайжруулж, тал нутгийг эвдэж хохируулсан ялт хэргийг илчлэн зарлаж, сэрэмжлүүлж чадсан байна.²⁴

ДҮГНЭЛТ

Дээрх байдлаас харахад, Өвөр Монголын нутаг бэлчээрийн асуудлаарх Хятад дахь судалгаа нь XX зууны 80-аад оноос эхлэлтэй байна. XX зууны 90-ээд оноос тал нутгийн эко орчинд цөлжилтийн асуудал хүндэрсэнтэй холбоотойгоор уг сэдэв нь судлаачдын анхаарлыг ихээр татах болж, холбогдох судалгааны бүтээлүүд олноор гарчээ. XXI зууны эхээс Хятадын бүх газар нутагт үйлдвэржилт, хотжилт хүчтэй явагдсаны улмаас Өвөр Монголын эдийн засгийн хөгжил, эко орчны доройтол, хүрээлэн буй орчны бохирдол, хүн амын өсөлт зэрэг олон талын зөрчилтэй асуудал тулгарах болсонтой зэрэгцэн судлаачид Өвөр Монголын үйлдвэржилт, хотжилтын алдаа оноог олон талаас судлаж ирснийг мэдэж болохоор байна.

24 Сюе Юань/薛原. Өвөр Монголын тал нутгийн нөөц баялгийн эрх зүйн хамгаалалт /内蒙古草原资源的法律保护[J]. Хууль дүрэм ба нийгэм/法制与社会, 2008, (19): 97-98.